



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН  
ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.01.17 № 05/687  
танай 2020.01.08-ны № 05/09 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад эх үүсвэр хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Даваагийн Дагвасүрэн, Газрын тосны ашиглалтын хэлтсийн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний ашиглалтын үе шатны хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Маамын Батдэлгэр нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч М.Батдэлгэр нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас" томилно гэж заасныг мөн төрийн жинхэнэ албаны албан тушаалын сонгон шалгаруулалтад хамрагдаагүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-д "... тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас ... авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд тухайн албан тушаалд Төрийн албаны тухай хууль болон дээрх тогтоолоор батлагдсан журамд нийцсэн этгээдийг нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0000678